



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 03 өдөр

Дугаар Д/433

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай.


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.12, "Барилгын тухай" хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.3, 42-р зүйлийн 42.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн "Хэнтий аймгийн алслагдсан багийн нутаг дэвсгэрт үүрэн холбооны сүлжээ оруулах ажлын цамхаг" ажлын зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ц.Бат-Эрдэнэ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Оюундарь	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Ш.Ариунболор	Аймгийн ерөнхий архитектор, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2.Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ